



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/173

Чингис хот

Төрийн архивын улсын үзлэгт бэлтгэх
комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "а", Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.5.1, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/173 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Төрийн архивын улсын үзлэгт бэлтгэх аймгийн комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|----------------------|--|
| Комиссын дарга: | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга |
| Орлогч дарга: | - Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга | - Архивын тасгийн дарга |
| Гишүүдэд: | -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| | - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | - Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч |
| | - Аймгийн ЗДТГ-ын бичиг хэргийн эрхлэгч |

2. Хууль зүйн дотоод хэргийн сайдын 2021 оны А/173 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, үзлэгийн бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах, үзлэгийг амжилттай зохион байгуулах, үр дүнг танилцуулахыг комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011978